



United Nations

Department of
Economic and
Social Affairs



**SUSTAINABLE
DEVELOPMENT GOALS**

ТХЗ-ыг үр дүнтэй хэрэгжүүлэх институцийн тогтолцооны дэлхий нийтийн чиг хандлага ба авууштай туршлага

Монгол Улсын Их Хурал, Монгол Улсын Засгийн газраас Монгол Улс дахь Нэгдсэн
Үндэстний Байгууллагатай хамтран зохион байгуулж буй
“Тогтвортой Хөгжлийн Зорилго” сэдэвт Үндэсний дээд хэмжээний чуулган
2020 оны 10-р сарын 4-ний өдөр

Давид Ле Бланк, НҮБ-ын Эдийн Засаг, Нийгмийн Газар



Төрийн байгуулал, дижитал Засгийн газрын хэлтэс



**United
Nations**

Department of
Economic and
Social Affairs

Илтгэлийн агуулга

- ТХЗ-ыг хэрэгжүүлэх институцийн тогтолцооны дэлхий нийтийн чиг хандлага
- ТХЗ-ын хэрэгжилтийг үндэсний түвшинд хянах, гүйцэтгэлийг хангуулах, үнэлж дүгнэх дэлхий нийтийн чиг хандлага
- ТХЗ-ын хэрэгжилтийг хангахад чиглэсэн олон талт оролцогчдын платформын жишээ, туршлага

ТХЗ-ыг хэрэгжүүлэх институцийн тогтолцооны дэлхий нийтийн чиг хандлага


Хөгжиж буй болон хөгжингүй улс орнуудад 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх тогтолцоо, институцын механизмыг өргөжүүлэн, гүнзгийрүүлэх

- Ихэнх улс орнууд дараахи чиглэлээр өөрчлөлт хийсэн. Үүнд:
 - ТХЗ-ыг хэрэгжүүлэх хууль эрх зүйн болон зохицуулалтын орчныг сайжруулсан
 - Үндэсний хөгжлийн бодлого, хөтөлбөрт ТХЗ-г нийцүүлэн тусгасан
 - ТХЗ-ыг хэрэгжүүлэх замын зураглал гаргах буюу үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулсан
 - ТХЗ-ын хэрэгжилтийн зохицуулалтыг хангах тодорхой бүтцийг Засгийн газарт бий болгосон
 - ТХЗ-ын хэрэгжилтийг хянах, гүйцэтгэлийг хангуулах, үнэлж дүгнэх үндэсний тогтолцоог бүрдүүлсэн.
- ТХЗ-ын хэрэгжилтийг зохион байгуулж буй улс орон бүрийн туршлага харилцан адилгүй бөгөөд “нийтлэг” хэв маягийг гаргах нь амаргүй юм.
- Тухайн улс орны улс төрийн нөхцөл байдал, тогтворгүй байдал нь ТХЗ-ыг хэрэгжүүлэх үндэсний түвшний институцийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэхэд нөлөөлж болно

Институцийн тогтолцоог хангах чухал 9 үе шатуудын 2020 оны байдлаархи гүйцэтгэл

24 улсыг
сонгон авч
хийсэн
судалгааны
жишээ



2020 оны
байдлаар,
гүйцэтгэлийг
хангасан улс
орны тоо, үе
шат нэг
бүрээр



Гүйцэтгэл хангагдсан чухал үе шатны тооны тархалт



2016

24 улсыг
сонгон авч
хийсэн
судалгааны
жишээ





Гүйцэтгэл хангагдсан чухал үе шатны тооны тархалт

24 улсыг
сонгон авч
хийсэн
судалгааны
жишээ



Гүйцэтгэл хангагдсан чухал үе шатны тооны тархалт

24 улсыг
сонгон авч
хийсэн
судалгааны
жишээ



ТХЗ-ын хэрэгжилтийг зохион байгуулж буй улс орон бүрийн туршлага харилцан адилгүй бөгөөд “нийтлэг” хэв маягийг гаргах нь амаргүй юм



Тухайн жилд чухал үе шатны гүйцэтгэлийг хангасан улс орны тоо



United Nations

Department of
Economic and
Social Affairs

ТХЗ-ын хэрэгжилтийг үндэсний түвшинд хянах, гүйцэтгэлийг хангуулах, үнэлж дүгнэх: дэлхий нийтийн чиг хандлага

- ТХЗ-ыг үндэсний хөгжлийн бодлого, хөтөлбөрт уялдуулан нутагшуулах, зохицуулалтийг хангах институцын механизмыг бүрдүүлж төгөлдөржүүлэх,
- ТХЗ-ын хяналт, гүйцэтгэлийг хангуулахад чиглэсэн бүтэц, зохион байгуулалтыг бий болгох
- Шалгуур үзүүлэлт, тоо мэдээллийн бэлэн байдлын чиглэлээр гаргаж буй ахиц дэвшил болон сорилтыг авч үзвэл:
 - Ихэнх улс орнууд ТХЗ-ын хэрэгжилтийг хянах дэлхийн хэмжээнд гаргасан нийтлэг шалгуур үзүүлэлтийг, эсхүл үндэсний түвшний ТХЗ-ын шалгуур үзүүлэлтүүдийг өөрсдөө боловсруулсан.
 - Тоо, мэдээллийн дутмаг байдал
 - Статистикийг хөгжүүлэх үндэсний стратеги нь тэр бүр ТХЗ-той нийцтэй бус буюу түүнд үндэслэн шинэчлэгдээгүй
 - КОВИД-19-өөс шалтгаалан тоо, мэдээллийг цуглуулах тогтолцоонд тасалдал үүссэн.
- ТХЗ-н үндэсний түвшний хэрэгжилтийн үнэлгээнээс Дэлхийн хэмжээний үнэлгээг авч үздэг болсон
- ТХЗ-ын хэрэгжилтийн явцын үндэсний тайлагнал нэмэгдсэн
 - Давтамж, анхаарал хандуулсан асуудал болон ТХЗ-д гарсан дэвшлүүд орнуудад харилцан адилгүй
- ТХЗ-ын хэрэгжилтийн үр дүнд хийсэн хараат бус буюу хөндлөнгийн үнэлгээ маш цөөн байна (Финлянд бол онцгой тохиолдол)



Төрийн байгуулал, дижитал ЗГ-ын хэлтэс (ТБДЗГХ)



United Nations

Department of
Economic and
Social Affairs

ТХЗ-ын хэрэгжилтийг үндэсний түвшинд хянах, гүйцэтгэлийг хангуулах: дэлхий нийтийн чиг хандлага (үргэлжлэл)

Орон нутгийн түвшинд

- Үндэсний түвшинтэй харьцуулахад ТХЗ-г нутагшуулах үйл явц харьцангуй бага байна.
- Гол анхаарлаа үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүдэд хандуулах ингэхдээ шаардлагатай арга аргачилалуудыг ашиглах.
- Үр дүнг тайлагнахдаа тухайн орон нутгийн онцлогийг харгалзах – сүүлийн үед, хэрэгжилтийн сайн дурын үнэлгээг орон нутгийн түвшинд хийдэг болсон

Хэрэгжилтийг үндэсний түвшинд хянадаг хянах, зохицуулах үүрэгтэй байгууллагуудын оролцоо:

- ТХЗ-ын хэрэгжилтэд хяналт тавихад Парламентийн гүйцэтгэх үүрэг улс орнуудад харилцан адилгүй байна
- Парламентийн түвшинд ТХЗ-н хэрэгжилтэнд хяналт тавих дотоод зохион байгуулалтууд орнуудад харилцан адилгүй байна
- Засгийн газрын зүгээс ТХЗ-ын хэрэгжилтийн явцыг Парламентад тогтмол тайлагнадаг жишээ цөөхөн байна
- Ихэнх улс орнуудад Үндэсний Аудитын Байгууллагыг ТХЗ-ын гүйцэтгэлийг үнэлж дүгнэх тогтолцоонд албан ёсоор оруулаагүй байна
- Гэхдээ, Үндэсний Аудитын Байгууллагууд тогтолцоог сайжруулахад тус нэмрээ нэмэгдүүлсээр ирсэн (Засгийн газрын ТХЗ-ыг хэрэгжүүлэх бэлтгэл ажилд аудит хийх, ТХЗ-ийн хэрэгжилтэд аудит хийх зэргээр)



Төрийн байгуулал, дижитал Засгийн газрын хэлтэс (ТБДЗГХ)



United Nations

Department of
Economic and
Social Affairs

ТХЗ-ын хэрэгжилтийг үндэсний түвшинд хянах, гүйцэтгэлийг хангуулах: чухалчилж авч үзэх асуудлууд, сорилтууд

Төрийн одоогийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоонд ТХЗ-н шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг тусган нэгтгэх

- Засгийн газрын бүхий л түвшинд үндэсний болон салбарын ХШҮ-ний тогтолцоонд ТХЗ-н шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг нэгтгэхтэй холбоотой сорилтууд
- Үр дүнг хэмжих, тайлагнахад учирч болох сөрөг нөлөөлөлүүд

Гүйцэтгэлийн тогтолцоонд мөн нутагшуулж, нэгтгэх

- ТХЗ болон одоогийн гүйцэтгэлийн тогтолцоо хоорондоо нягт холбогдох нь ховор байна (жишээлбэл, төсөв).

Хэрэгжилтийн үр дүнг дараагийн төлөвлөлтөд тусгах эргэх холбоос

- Шийдвэр гаргахдаа баримт нотолгоо болон бодит тоо мэдээлэлд тэр бүр тулгуулахгүй байна
- Зарим нэгэн онцгой тохиолдол: Финляндын хараат бус буюу хөндлөнгийн үнэлгээ; зарим улс оронд ТХЗ-ын аудитын зөвлөмжийг хүлээж авсан жишээ байна



Төрийн байгуулал, дижитал ЗГ-ын хэлтэс (ТБДЗГХ)

ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд оролцогч талуудын хүлээх үүрэг буюу оролцоо: Дэлхий нийтийн чиг хандлага

- ТХЗ-г үндэсний түвшинд нутагшуулах тогтолцоо бүрдүүлэх үйл явцад оролцогч талуудын оролцоо, үүрэг роль улам нэмэгдсээр байна
- Гэсэн хэдий ч, төрийн болон төрийн бус оролцогч талуудын оролцооны түвшин улс орнуудад харилцан адилгүй байна
- ТХЗ-г нутагшуулах үндэсний тогтолцоогоо сайжруулсанаар оролцогч талуудын оролцоог, тэдний үүрэг ролийг нэмэгдүүлэх, хамтын үр дүн гаргах асар их боломжууд байна
- ТХЗ-ыг хэрэгжүүлэх, хяналт, үнэлгээ хийх чадавхийг бэхжүүлэх чиглэлээр бусад орны сайн туршлагаас сурах, хуваалцах боломж их байна




United Nations

Department of
Economic and
Social Affairs

Төрийн бус оролцогч талуудын оролцоог хангах, тэднийг татан оролцуулах: жишээ

- ТХЗ-г нутагшуулах, энэ үйл явцыг удирдан зохион байгуулах тогтолцоонд оролцуулах
- Үндэсний зөвлөлдөх хороод, тэдний үйл ажиллагаанд оролцуулах (жишээлбэл, Тогтвортой хөгжлийн үндэсний хороо гэх мэт)
- ТХЗ-н шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг үндэсний болон орон нутгийн түвшинд тодорхойлоход оролцуулах
- ТХЗ-ын хэрэгжилтийн явцад хяналт тавих, тайлагнах үйл явцад оролцуулах (ТХЗ-ын хэрэгжилтийн үндэсний тайлан боловсруулах/үндэсний сайн дурын тайлагналт, ТХЗ-ын хэрэгжилтийн явцад хөндлөнгийн үнэлгээ дүгнэлт өгөх; орон нутгийн түвшний сайн дурын үнэлгээ дүгнэлт гэх мэт)
- Шинжлэх ухаан болон бодлого боловсруулах, шийдвэр гаргах хамтын ажиллагааг сайжруулах
- ТХЗ-той холбоотой мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх
- Төрийн албан хаагчид, иргэний нийгмийн чадавхийг бэхжүүлэх

Тогтолцоонд оролцогч талуудын хүлээх үүрэг буюу оролцоо: Финлянд





United Nations

Department of
Economic and
Social Affairs

Олон талын оролцогчид: Эстонийн Тогтвортой хөгжлийн комиссын бүтэц, бүрэлдэхүүн

- Эстонийн үйлдвэрчний эвлэлийн холбоо
- Эстонийн худалдаа, аж үйлдвэрийн танхим
- Эстонийн байгаль орчны менежментийн холбоо
- Эстонийн Байгаль орчны төрийн бус байгууллагуудын зөвлөл
- Эстонийн хотуудын холбоо
- Эстонийн байгаль хамгаалах нийгэмлэг
- Эстонийн орон нутгийн засаг захиргаадын холбоо
- Эстонийн ойн нийгэмлэг
- Эстонийн өвийн нийгэмлэг
- Эстонийн Залуучуудын үндэсний зөвлөл
- Эстонийн Хөдөө аж ахуй, худалдааны танхим
- Эстонийн шинжлэх ухааны академи
- Эстонийн эрүүл мэндийг дэмжих холбоо

- Эстонийн хүүхдийн сайн сайхны төлөө эвсэл
- Эстонийн боловсролын форум
- Эстонийн соёлын танхим
- Эстонийн их сургуулиуд
- Эстоны хамтын ажиллагааны ассамблей

2016 оноос хойшхи хугацаанд комиссын үйл ажиллагаанд оролцож ирсэн байгууллагууд:

Эстоны хөгжлийн хамтын ажиллагааны дугуй ширээний ярилцлага

Эстони Улсын Ромын клубын холбоо


Эстонийн сэргээгдэх эрчим хүчний холбоо

Эстонийн хариуцлагатай бизнес форум

Эх сурвалж: Эстони, 2020
СДҮҮД-ийн тайлан, хуудас9.

ТХЗ-ын иргэний нийгмийн платформ: Кени улс

- Иргэний нийгмийн 350 гаруй байгууллагыг эгнээндээ нэгтгэсэн ТХ-ийн төлөөх Кенийн чуулган
- ТХЗ-ын талаарх мэдээллийг цуглуулж түгээдэг: <https://sdgkenyaforum.org/>
- Кени Улс дахь ТХЗ-ын хэрэгжилтийн тайлан гаргадаг
- Эдүгээ, Засгийн газар, хувийн хэвшлийн шүхэртэй бүлэгтэй хамтран Төрийн сан, төлөвлөлтийн яамны ТХЗ-ын зохицуулалтын газарт дэмжлэг үзүүлдэг байгууллага хоорондын техникийн ажлын хороо (IATWC)-г хамтран удирддаг.





United Nations

Department of
Economic and
Social Affairs

ТХЗ-ын төв платформ: Индонез улс

- <http://sdgs.bappenas.go.id/>
- Төлөвлөлтийн яам ажиллуулдаг (Bappenas)
- ТХЗ-ын талаарх бүхий л хууль эрх зүй, зохицуулалт, төлөвлөлттэй холбоотой мэдээлэл, удирдамж зааварчилгаа болон бусад эх сурвалжийг төвлөрүүлдэг
- Индонезийн ТХЗ-ын dashboard холбоос: <http://sdgs.bappenas.go.id/dashboard/>





**United
Nations**

Department of
Economic and
Social Affairs

Баярлалаа

Дэлгэрэнгүй мэдээллийг Дэлхийн улсын салбарын 2021 оны тайлангаас үзэж танилцах боломжтой: <https://publicadministration.un.org/en/Research/World-Public-Sector-Reports>